УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 09 өдөр Дугаар А/134 Улаангом

Шагналд тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Үйлчилгээний гавьяат ажилтан"

1. Орхи овогтой Төмөрсанаа- Шуудан үйлчилгээний салбарын ахмад ажилтан

Хоёр".Гавьяат тамирчин"

1. Бадамсамбуу овогтой Мөнх –Оргил- Диф Олимпийн хошой мөнгөн медалт тамирчин

Гурав. Хөдөлмөрийн гавьяаны улаан туг"-ийн одонгоор

1. Мягмар овогтой Батжаргал- Улаангом сумын 11-р багийн өндөр настан
2. Раднаа овогтой Ядамсүрэн – Увс Финанс " аудит ХХК-ы захирал
3. Дамба овогтой Ринчинсамбуу- Баянхайрханы чоно " ХХК-ы ерөнхий захирал

Дөрөв. "Алтан гадас" одонгоор

1. Зана овогтой Цогзолмаа- Шинэ барилга –Увс ХХК-ы захирал
2. Ойдов овогтой Батням- "Энержи Импайр "ХХК-ы ажилтан
3. Норов овогтой Нүрзэд – Увс аймгийн Боловсролын салбарын ахмад ажилтан
4. Жумдаа овогтой Пэрэнлэй- Увс аймгийн Боловсролын салбарын ахмад ажилтан
5. Гэлэгжүгнээ овогтой Лхагвасүрэн- Улаангом сумын 6-р багийн иргэн
6. Жигжид овогтой Ганцог- Ахлах 3-р сургуулийн мужаан
7. Чимэддорж овогтой Чулуунбат- Зүүнхангай сумын өндөр настан
8. Энэбиш овогтой Өлзийжаргал- Зүүнхангай сумын өндөр настан
9. Төрбат овогтой Мөнхжаргал- Улаангом сумын 1-р багийн өндөр настан
10. Норжин овогтой Буянжаргал- Ховд сумын Ачит багийн малчин
11. Чилхаасүрэн овогтой Надмид- Баянхайрханы чоно " ХХК-ы ерөнхий менежер

001251

12. Лхамсүрэн овогтой Болдоо- Баянхайрханы чоно " ХХК-ы менежер
13. Түвдэн овогтой Уртнасан – Боловсролын ахмад ажилтан

Тав. "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар

1. Эмээ овогтой Балжинням- Ус цаг уур орчны шинжилгээний албаны ахмад ажилтан
2. Түмэнжаргал овогтой Цэвээнгэрэл- Ус цаг уур орчны шинжилгээний албаны ажилтан
3. Цэен овогтой Нямсүрэн- Ахлах 2-р сургуулийн манаач
4. Жадамба овогтой Жаргалсайхан- Улаангом сумын 5-р багийн иргэн
5. Сайндүүрэн овогтой Нацагдорж- Авто тээвэрчдийн нэгдсэн холбооны ахмад тээвэрчин
6. Зундуй овогтой Энхээ- Улаангом сумын ахмад багш
7. Цумба овогтой Цэдэнбал- Ахмад тээвэрчин
8. Намдаг овогтой Батжаргал – Ахлах 2-р сургуулийн нярав
9. Цэвээн овогтой Цэцэгмаа- Нархан цэцэрлэгийн ахлах тогооч
10. Лодой овогтой Сэржим- Нархан цэцэрлэгийн тогооч
11. Эрхэмбаяр овогтой Мөнхбат- Барилгын инженер
12. Баглаа овогтой Цэдэн – Эрүүл мэндийн салбарын ахмад ажилтан

нарыг шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ДАРГА Ч.ЧИМЭД

УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 09 өдөр Дугаар А/135 Улаангом

Үндсэн хөрөнгийн тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

Нэг.Орон нутгийн өмчит байгууллагуудын худалдах,орон нутгийн өмчийг балансаас балансад шилжүүлэх хөрөнгийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба /Х.Төртогтох/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ЧИМЭД

001257

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны -р сарын -ны өдрийн
.... тоот тогтоолын хавсралт

Орон нутгийн өмчит байгууллагуудын худалдан борлуулах, актлах, балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Нэг: Дуудлага худалдаагаар худалдан борлуулах хөрөнгө

мян/төг

№	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Худалдах үнэ
1	Малчин сумын Ахлах сургууль	75 хүүхдийн дотуур байр	1974	1	500125	337584,4	162540,6	44000,0
2	Өндөрхангай сумын ЗДТГ	Кама SD4010PD3 маркийн өөрөө буулгагч машин	2012	1	17800	9399,44	8400,56	8400,0
	Дүн				**517925**	**346983,84**	**170941,16**	

Хоёр: Актлаж, данс бүртгэлээс хасах хөрөнгө

мян/төг

№	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Завхан сумын ЗДТГ	Баяр наадмын талбайн төв асар, сандал, жорлон	2011	1	6448,8	671,7	5777,0
	Дүн	**0**			**6448,8**	**671,7**	**5777,0**

Гурав: Балансаас балансад шилжүүлэх хөрөнгө

№	Шилжүүлэх Байгууллагын нэр	Хүлээн авах байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Завхан сумын ЗДТГ	Завхан сумын Цэцэрлэг	Наадмын талбайн Төмөр хашаа	2011	28 метр	471,3	49,1	422,2
2	Завхан сумын ЗДТГ	Завхан сумын Ахлах сургууль	Наадмын талбайн Төмөр хашаа	2011	174 метр	2928,7	305,1	2623,6
	Дүн				**202**	**3400,0**	**354,2**	**3045,8**

УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 09 өдөр Дугаар А/136 Улаангом

Газрын кадастрын мэдээллийн сангийн
Лэнд менежер программыг нэвтрүүлэх тухай

Аймгийн засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн газрын кадастрын “Лэнд менежер” программ хангамж нэвтрүүлэх, үйл ажиллагаатай холбогдуулан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах захирамжийг кадастрын мэдээллийн сан болон газар дээрх бодит талбайтай нь харьцуулан гаргасан 19 сумын 6434 нэгж талбарын зөрүүг арилгах тухай асуудлыг авч хэлэлцээд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн, 18 дугаар зүйлийн 18.1.2 “з”, 20 дугаар зүйлийн 20.1дэхь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Газрын харилцааны бүртгэл хяналтын тогтолцоог сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэх газрын харилцааны мэдээллийн сангийн “Лэнд менежер” программ хангамжийг нэвтрүүлэхийг дэмжсүгэй

Хоёр. “Лэнд менежер” программ хангамжийг нэвтрүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан газрын талбайн хэмжээ болон захирамжийн зөрүүтэй мэдээллийг засварлаж, зөрчил арилгах ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавьж үр дүнг тооцож ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж техникийн болон программ хангамжийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар /Г.Отгонболд/-т үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ЧИМЭД

001251

УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 10 сарын 09 өдөр Дугаар А/137 Улаангом

Газрын зориулалт өөрчлөхийг
дэмжих тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "з", 20 дугаар зүйлийн 20.1 дахь заалт, "Газрын тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Улаангом сумын 5-р багт Гашууны гол явах замын дээд талд байрлах "Дашвааанжил" ХХКомпаний жимс, жимсгэний зориулалтаар эзэмшдэг 1га газрыг шингэрүүлсэн хий түгээх станц болон агуулахын зориулалтаар эзэмшүүлэхээр өөрчлөхийг дэмжсүгэй.

Хоёр. "Дашвааанжил" ХҲК-д шингэрүүлсэн хий түгээх станц болон агуулахын зориулалтаар эзэмшүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг дарга / Д. Цэндсүрэн /-д үүрэг болгосугай

ДАРГА Ч.ЧИМЭД

001255